



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН  
ЗӨВЛӨЛ

# МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ҮНДСЭН САНАЛУУД

# 2026





## МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ҮНДСЭН САНАЛУУД

Монголын Бизнесийн Зөвлөл ТББ (МБЗ) нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон өмчийн эрх, эдийн засгийн эрх чөлөөг дэмжих, шударга, тогтвортой, олон улсад өрсөлдөхүйц бизнесийн орчныг бүрдүүлэх, гишүүн байгууллагуудын нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Монгол Улсын Засгийн газраас татварын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор холбогдох татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг өргөн мэдүүлсэн нь чухал алхам боловч эдгээр нь бизнесийн орчныг бодитой сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай цогц өөрчлөлтийг бүрэн хангаж чадаагүй байна.

Монгол Улс татварын хувь хэмжээгээр олон улсын жишигт ойролцоо боловч шууд болон шууд бус татваруудын нийлбэр нөлөөллөөр аж ахуйн нэгжүүдэд ногдох үр ашигт татварын ачаалал өндөр хэвээр байна. Үүнээс гадна татварын маргааны хүрээнд маргаан эцэслэгдээгүй байхад нөхөн ногдуулалт нэхэмжлэх, данс царцаах зэрэг практик нь аж ахуйн нэгжүүдэд өндөр дарамт үүсгэж, үйл ажиллагааг доголдуулах, цаашлаад дампууралд хүргэх эрсдэл бий болгож байна.

МБЗ нь гишүүн байгууллагуудтайгаа хамтран татварын орчны судалгаа хийж, хувийн хэвшилд тулгарч буй 60 гаруй асуудлыг нэгтгэн дүгнэсэн. Эдгээр нь ААНОАТ, суутган татвар, АМНАТ, НӨАТ, ХХОАТ зэрэг үндсэн татваруудтай холбоотой бөгөөд одоогийн зохицуулалтын нарийн төвөгтэй байдал нь бизнесийн санхүүгийн ачааллыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Эдгээрээс бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай тэргүүлэх найман санал, зөвлөмжүүдийг энэхүү баримт бичгээр хүргүүлж байна.

## ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

**1** Эрх борлуулсан шилжүүлсний татвар (ЭШТ)

**2** АМНАТ

**3** Суутган татвар (20%)

**4** Буцаан олгодоггүй НӨАТ-ын зардал

**5** Татварын маргааны механизм

**6** Холдинг бүтэц

**7** Шаталсан ХХОАТ

**8** Татварын орчны тогтворжуулалт





## Эрх борлуулсан, шилжүүлсний орлогод ногдох албан татвар

1

ААНОАТ-н тухай хуулийн 30 дугаар зүйл “Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг борлуулах, шилжүүлэх замаар газар эзэмших, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн эрх борлуулсан, шилжүүлсний орлогод тооцно.”



**Энэхүү хуулийн зохицуулалтаас болж бодит байдал дээр дараах асуудлууд тулгарч байгаа бөгөөд цаашлаад гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжгүй болгож байна. Үүнд:**

ЭШТ-ын ногдлыг тооцоолох аргачлалаар татварын ногдлыг шууд бус байдлаар ногдуулж байгаа нь бодит хэлцлийн үнээс асар их зөрүү гаргадаг. Жишээ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд өнөөгийн үнэ цэний аргаар татвар ногдуулахдаа тухайн төслийн ирээдүйн бүх мөнгөн урсгалаас нэг дор татварыг урьдчилан авч байгаа нь хөрөнгө оруулагчийн шаардах хөрөнгө оруулалтын хэвийн өгөөжийг үгүй болгож хөрөнгө оруулах боломжгүй болгодог.

ААНОАТ-ын тухай хуулийн 30.2-т заасны дагуу эцсийн эзэмшигчид ногдох татварыг тухайн эрх эзэмшигч буюу Монгол дахь хуулийн этгээдээр төлүүлэхээр зохицуулсан. Эрх эзэмшигч компани нь тусдаа бие даасан хуулийн этгээд бөгөөд зөвхөн өөрийн олсон татвар ногдох орлогодоо татвар төлөх ёстой байтал тухайн компанийн шууд болон шууд бус хувьцаа эзэмшигчийн өмнөөс хувьцаа борлуулсан татварыг нь үүрэх ёсгүй. Энэ нь компани хувь нийлүүлсэн өөрийн хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээх, компанийн эд хөрөнгө түүний хувьцаа эзэмшигчээс ангид байх гэсэн үндсэн зарчмыг ноцтой гажуудуулж байгаа юм.


Эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн хувьцааг борлуулах замаар орлого олох үед “хувьцаа, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл борлуулсны орлого”-ын татвар төлдөг ба нэмээд төрийн байгууллагаас олгосон эрх борлуулж орлого олж байна гэж үзэн мөн татвар ногдуулж байгаа нь нэг гүйлгээн дээр хоёр төрлийн татвар давхардуулан ногдуулж байгаа хэрэг юм.

Дээрх асуудлуудын хүрээнд ЭШТ-г болиулахаас нааш гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлэх боломжгүй байна.



## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

ААНОАТ-ын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно” гэж заасан байдаг ба энэхүү заалтыг хүчингүй болгохыг санал болгож байна.



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 30 дугаар зүйлийн 30.2	“Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно”	<del>“Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно”</del>	Хасах



## Үр ашигт татварын түвшинг хэт өндөр болгож буй хамгийн том хүчин зүйл нь АМНАТ байна.

# 2

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд АМНАТ-ийг хэрхэн ногдуулж тооцоолох талаар буюу АМНАТ төлөгч нь бүх төрлийн ашигт малтмалын “борлуулалтын үнэлгээнээс” АМНАТ-ийг төлнө гэж заасан байдаг. АМНАТ-ийг зөвхөн жишиг үнээр тооцдогос болж аж ахуйн нэгжүүд үндэслэлгүй татвар төлөхөд хүрч, татварын ерөнхий хуульд заасан шударга, үр ашигтай байх зарчим алдагдлаа гэж үзэж байна. Уул уурхайн салбар хөгжсөн улсууд болох Чили, Канад, Перу, болон Австралид АМНАТ-ийг борлуулалтын нийт дүнд бус ашигт суурилсан үнэлгээн дээр үндэслэн төлдөг (доорх хүснэгтээс харна уу). Түүнчлэн, улс орнуудын АМНАТ ногдуулах суурь нь үйл ажиллагааны ашиг, татварын өмнөх ашиг зэрэг өөр өөр суурийг ашигладаг байна. Ашигт суурилсан энэ аргын гол ач холбогдол нь уул уурхайн томоохон эрсдэлийг төр, хөрөнгө оруулагчдын хооронд жигд хуваарилахтай холбоотой юм. Одоогийн борлуулалт/жишиг үнэлгээнд суурилсан төлбөрийг ашигт суурилсан үнэлгээний аргаар сольсноор манайх шиг уул уурхайн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 90 гаруй хувийг бүрдүүлдэг улсын хувьд салбараа дэмжиж, их хэмжээний хөрөнгө оруулалт татах боломжийг нээж өгөх болно.



	Австрали	Канад	Чили	Перу	АНУ
Татварын Суурь	Уул уурхайн ашиг	Татварын өмнөх ашиг	Тохируулсан татварын өмнөх ашиг	Татварын өмнөх ашиг	Тохируулсан татварын өмнөх ашиг

АМНАТ-ийн нэмэгдүүлэн бодох хувийг тухайн бүтээгдэхүүний эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоод болон гадаадын зах зээлийн үнийн түвшинд суурилан тодорхойлдог. Зах зээлийн үнийн түвшин 1 ам. доллар-р л нэмэгдэхэд АМНАТ-ийн нэмж ногдуулах хувь хэмжээг тухайн экспортлосон ашигт малтмалын зах зээлийн нийт үнийн дүнд суурилан тооцдог. Жишээ нь:

Зэсийн зах зээлийн үнийн түвшин 1 ам. доллар-р нэмэгдэж 6,001 ам доллар болоход хүдрийн боловсруулалтын түвшинд 22%-иас 24%, баяжмалд 12%-иас 13% болон нэмэгдэж байна. Энэхүү нэмэгдсэн хувь хэмжээг нийт зах зээлийн үнийн дүнд буюу нийт 6,001 ам. долларт ногдуулж байгаа нь АМНАТ-н зардлыг асар их хэмжээгээр нэмэгдүүлдэг.



## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

Ашигт малтмалын тухай хуулийн 47.16-р зүйлд “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь доор дурдсан үйл ажиллагаанд бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө” гэж заасан байдаг ба энэхүү борлуулалтын үнэлгээнээс гэсэн хуулийн заалтыг “Татварын өмнөх ашиг”-с хэмээн өөрчлөх;



Ашигт Малтмалын тухай Хуулийн 47.5 дах хэсэгт заасанчлан АМНАТ-н нэмэгдүүлэн бодох хувийг зах зээлийн үнийн түвшин 1 ам. доллар-р л нэмэгдэхэд АМНАТ-н нэмж ногдуулах хувь хэмжээг тухайн экспортлосон ашигт малтмалын зах зээлийн нийт үнийн дүнд суурилан тооцдог. Иймд дээрх жишгийг халж оронд нь прогрессив хэлбэрээр тогтоосон шатлалыг үнийн дүнгээс илүү гарсан дүнд л (дээрх тохиолдол 1 ам. доллар) нэмэлт хувь хэмжээг ногдуулж төлдөг арга барил руу шилжүүлэх нь зүйтэй байна. Саналын дэлгэрэнгүйг Хавсралтаар оруулав.

Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 30 дугаар зүйлийн 30.2	“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь доор дурдсан үйл ажиллагаанд бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө”	“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь доор дурдсан үйл ажиллагаанд бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс <b>татварын өмнөх ашгаас</b> ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө”	Өөрчлөх санал



## Суутган татвар нь оршин суугч бус татвар төлөгчдөд өндөр татварын дарамт учруулж байна.

3

Суутган татвар нь оршин суугч бус татвар төлөгчдөд өндөр татварын дарамт учруулж байна.

Практикт ААН-үүд гэрээнд заасны дагуу гадаадын ААН-үүдрүү үйлчилгээний төлбөр шилжүүлэх үед ААНОАТ-ын тухай хуулийн 20.2.4-д заасан 20%-ийн суутган татварын үүргийг биелүүлээгүйгээс болж энэ татварын дарамтыг өөр дээрээ шилжүүлэн авдаг. Өөрөөр хэлбэл, энэ зохицуулалт нь "суутган авах" гэсэн утгаа алдаж, үйлчилгээний төлбөрөөс суутгахгүйгээр нэмэлт татварын ачаалал үүрч, дотоодын бизнесийн байгууллагуудын хувьд энэхүү 20% татвар нь НӨАТ-тай адил зарчмаар үйлчилж байна.



## Татварын суурийн ялгаатай байдал

### Оршин суугч этгээд:

“Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэж заасан. Үүний дагуу оршин суугч этгээд цэвэр ашигаасаа татвар төлдөг.

### Оршин суугч бус этгээд:

ААНОАТ-ын тухай хуулийн 18.6: Оршин суугч бус татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлогын төрөл тус бүрийн нийт дүнгээр тооцно. Энэ заалтын дагуу оршин суугч бус татвар төлөгч нийт орлогоосоо татвар төлдөг.

Иймд оршин суугч бус татвар төлөгчийн орлогын нийт дүн дээр биш цэвэр дүн дээр татвар ногдуулж гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, цаашлаад орлогын шинж чанараас хамааран суутган татварыг 5-10% хүртэл бууруулвал зохистой. Мөн ОУ-ын жишгийн дагуу үйлчилгээний төлбөр болон хувьцаа худалдах үед 20%-ийн суутган татвар ногдуулдаг зохицуулалтыг болиулах шаардлагатай байна.



## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

ААНОАТ-ын тухай хуулийн 20.2.4-р заалтад “энэ хуулийн 18.6.6, 18.6.8, 18.13-т заасан орлогод 20 хувиар” гэж заасан байдаг ба энэхүү хуулийн 20 хувиар гэснийг орлогын шинж чанараас хамааран 5-10 хувиар болгон бууруулах хэмээн хуульд нэмэлт , өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 20 дугаар зүйлийн 20.2	20.2. “Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна.” 20.2.4.”энэ хуулийн 18.6.6, 18.6.8, 18.13-т заасан орлогод 20 хувиар;”	20.2. “Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна.” 20.2.4.”энэ хуулийн 18.6.6, 18.6.8, 18.13-т заасан орлогод <del>20</del> 5 хувиар;”	Өөрчлөх санал



## Буцаан олгодоггүй НӨАТ-ын зардал

# 4

НӨАТ бизнес эрхлэгчдэд дарамт учруулах ёсгүй хэдий ч МУ-ын хувьд НӨАТ-ыг ААНОАТ шиг ашиглаж байна. ААН-үүдийн хувьд буцаан олгогддоггүй НӨАТ-ын зардлууд бий. Хасагдах худалдан авалтын НӨАТ-ын хувьд хэдий хуульд НӨАТ-ын буцаан олголтыг зөвшөөрдөг ч практикт буцаан олгодоггүй ба НӨАТ-ын авлагыг бусад татварын өр төлбөрт суутгадаггүй тул эцэстээ орлогын тайланд алдагдлаар бүртгэгддэг. НӨАТ-ын хууль ёсны буцаан олголтыг хэрэгжүүлж, процессыг тодорхой болгосноор уг асуудлыг шийдэж чадах юм. Мөн уул уурхайн төслүүдийн байнгын хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд худалдан авалтын НӨАТ-ыг аль болох эрт буцаан олгох татварын зохицуулалтыг хэрэгжүүлэх нь чухал байна.



**Хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгохын тулд НӨАТ-ын систем нь бизнес эрхлэгчдэд ямар нэгэн дарамтгүй байх хэрэгтэй.**



### Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

Одоогийн НӨАТ-ын тухай хуульд зааснаар: “15.1.1. албан татвар суутган төлөгч буцаан авах хүсэлтээ албан татварын тооцоо хийж, тайлан тушаах үедээ харьяалах татварын албанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ; 15.1.2. харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, баталгаажуулахаар албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” гэсэн байгааг доорх байдлаар өөрчлөх:

“15.1.2. Харьяа татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, Татварын ерөнхий хуулийн 6.1.15-д заасан актын төслийг холбогдох материал, баримт бичгийн иж бүрдлийн хамт татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар хүргүүлнэ.”

“15.1.3. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын актын төслийг ажлын 7 хоногийн дотор нягтлан шалгаж, баталгаажуулна.

15.1.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 15.1.3-т заасан саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 10 өдөрт багтаан татварыг буцаан олгох шийдвэрийг гаргана.”



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 15 дугаар зүйлийн 15.1.2	15.1.Албан татвар суутган төлөгчийн илүү төлсөн албан татварыг дараах журмаар буцаан олгоно: 15.1.2.харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, баталгаажуулахаар албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”	15.1.2. “Харьяа татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, <del>багтаан хянан шалгаж, баталгаажуулахаар албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ</del> Татварын ерөнхий хуулийн 6.1.15-д заасан актын төслийг холбогдох материал, баримт бичгийн иж бүрдлийн хамт татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар хүргүүлнэ.”	Өөрчлөх санал
15 дугаар зүйлийн 15.1		15.1.3. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын актын төслийг ажлын 7 хоногийн дотор нягтлан шалгаж, баталгаажуулна.	Нэмэх санал
15 дугаар зүйлийн 15.1		15.1.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 15.1.3-т заасан саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 10 өдөрт багтаан татварыг буцаан олгох шийдвэрийг гаргана.	Нэмэх санал



## Татварын албаны үйл ажиллагаа нь аж ахуйн нэгжүүдийг дампууралд хүргэж байна

5

2020 оны Татварын ерөнхий хуулийн (ТЕХ) нэмэлт өөрчлөлтөөр татварын албан хаагчид маргаан шийдвэрлэгдэхээс өмнө маргаантай татварын дүнг бүрэн төлөхийг шаардах эрхтэй болсон. Албан ёсны татварын маргаан үүссэн тохиолдолд, маргаан эцэслэн шийдэгдэхийг хүлээлгүй шууд бүх төлбөрийг авах нь хэт ширүүн арга хэмжээ болж байна. Мөн сүүлийн үед ТЕГ уг төлбөрийг төлөхийг шаардан дахин дахин мэдэгдэл илгээж, цаашлаад ААН-н банкны дансыг нь хүртэл царцаахаар сүрдүүлж бизнесийг дампууралд хүргэх хүртэл эрсдэлд оруулж байна.



Цаашлаад ТЕХ-ийн дагуу татварын алба нь нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10%-г урьдчилж төлөхийг шаардах болсон ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөр хязгаарлагддаг. Энэ шаардлага нь эргээд нэмэлт дарамт болж, татварын актыг эсэргүүцэх хүсэлтэй ААН-ын тоог бууруулдаг. Татварын актыг эсэргүүцэж, маргаан шийдвэрлэх гомдол гаргахыг хүсэж буй бизнесүүдийн хувьд энэ шаардлага нь санхүүгийн хувьд дарамттай байдаг. Зарим бизнесүүд татварын актыг эсэргүүцэхээс

## ОУ-ын хөрөнгө оруулагчдын дунд МУ-ын нэр хүндийг доош татаж буй энэхүү түрэмгий арга хэмжээг таслан зогсоож ААН-дэд эрх тэгш байдлыг олгох шаардлагатай байна.

зайлсхийдэг шалтгаан нь хэт төвөгтэй гэж үзсэнд байдаг бол зарим нь шаардлагыг биелүүлэх санхүүгийн нөөцгүй байх тохиолдол ч байдаг. Татварын акт буцаагдсан эсвэл буруу гэж шийдвэрлэгдсэн тохиолдолд уг урьдчилж төлсөн дүнг буцаан олгох хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй.





## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

ТЕХ-ийн 47 дугаар зүйлийн 47.3-т зааснаар “Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна”.

ТЕХ-ийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй” гэж заасан байдаг. Энэхүү хоёр заалтыг хүчингүй болгож татварын хяналт шалгалтын үр дүнд гарсан нөхөн ногдуулалтын акттай холбоотой ААН гомдол гаргасан тохиолдолд, холбогдох татварын өрийг гомдол эцэслэгдэн шийдэгдэх үл маргах журмаар хурааж авахыг хориглох гэж ТЕХ-д өөрчлөн оруулах саналтай байна.



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Татварын ерөнхий хууль, 43 дугаар зүйлийн 43.3	43.3. “Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.”	<b>43.3. “Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.”</b>	Хүчингүй болгох санал
47 дугаар зүйл 47.3	47.3. “Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.”	<b>47.3. “Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.”</b>	Хүчингүй болгох санал




## Групп компанийн бүтцийн хувьд татварын ээлтэй орчин байхгүйн улмаас дотоодын ААН-үүд гадаадад толгой компаниа байгуулж байна

6

МУ-ын групп компаниудад зориулсан тусгайлсан татварын зохицуулалт байхгүйгээс үүдэн олон давхарга бүхий бүтэцтэй байх шаардлагатай групп компаниудын үр ашигт татварын түвшин (ҮАТТ) нь ойролцоогоор 50% болдог. Энэ нь дотоодын групп компаниудын өсөлтийн боломжийг хязгаарлаж байна. Иймд Групп компанийн хооронд төлөгдсөн ногдол ашиг болон хувьцаа, хөрөнгө борлуулсны орлогыг татвараас чөлөөлж, орчин үеийн ОУ-ын стандартад нийцсэн, тусгайлсан татварын зохицуулалтыг бий болгох хэрэгтэй.



## Бусад улс орнуудын холдинг компанийн ҮАТТ-г МУ-тай харьцуулахад:





## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

ААНОАТ-ын тухай хуульд “групп компанийн татварын зохицуулалт” гэсэн шинэ бүлэг нэмэх.

Охин компанийн өөрийн толгой компанидаа шилжүүлсэн ногдол ашгийн орлогыг татвараас чөлөөлөх татварын зохицуулалтыг бий болгох.



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, 21 дүгээр зүйлийн 21.1	21.1.Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө: ...	“21.1.18 Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого.”	Нэмэх санал



## Хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар нь бизнесийн орлогын татвараас өндөр байна

# 7

Аливаа улс орон ХХОАТ-ын шаталсан хувь хэмжээг анх нэвтрүүлэхдээ хөрөнгийн орлоготой чинээлэг давхаргын орлого болох ногдол ашгийн орлого, хүүгийн орлогоосоо эхэлж өндөр хувь хэмжээгээр татвар авдаг ба шаардлагатай тохиолдолд хамгийн сүүлд цалингийн орлогод шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг практик бий. Гэтэл манай улс чадварлаг боловсон хүчний хомсдолтой энэ цаг үед тэр боловсон хүчнийхээ цалин хөлсний орлогоос өндөр татвар ногдуулан авч улам МУ-д ажиллаж хөдөлмөрлөх сонирхолгүй болгож байна. Тийм учраас цалин хөдөлмөрийн хөлсний орлогод шатлалгүй 10%-н ХХОАТ ногдуулдаг байхаар өөрчлөх шаардлагатай байна.



Жилийн орлого (₮)	Татварын хувь	Албан татварыг тооцох арга
Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, 21 дүгээр зүйл	21.1.Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө: ...	“21.1.18 Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого.”
0 - 120,000,000	10%	Нийт орлогын 10%
120,000,001 – 180,000,000	15%	12,000,000₮ + (120,000,000₮- өөс давсан орлогын 15%)
180,000,000 ба түүнээс дээш	20%	21,000,000₮ + (180,000,000₮- өөс давсан орлогын 20%)



## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

ХХОАТ-ын тухай хуулийн 21.1 дүгээр зүйлийн шаталсан хувь хэмжээг “Цалин хөдөлмөрийн хөлсний орлогод шатлалгүй 10%-н ХХОАТ ногдуулдаг” байхаар өөрчлөн оруулах саналтай байна.



Хууль	Хуулийн холбогдох зохицуулалт	Шийдвэрлэх санал	Саналын төрөл
Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 21 дүгээр зүйл	“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна”	“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”	Өөрчлөх санал




## Татварын тогтворгүй байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг буруулж байна

# 8

Одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөрөнгө оруулалттай холбоотой хуулийн заалтуудыг харвал манай улсад хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тэр дундаа татварын орчныг тогтвортой байлгахтай холбоотой хууль тогтоомжийн бүрэн гүйцэд нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Хөрөнгө оруулалт нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулдаг тул тус харилцааны эрх зүйн орчин тэр дундаа татварын орчны тогтвортой байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт тодорхой байх учиртай. МУ-ын хувьд эдийн засгийн үзүүлэлт боломжит түвшнээс доогуур байгаа тул өсөлт, хөрөнгө оруулалтыг дэмжих бизнесийн таатай орчин нэн шаардлагатай байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид манай улсын татварын орчинг тогтворжуулахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтуудыг тогтворгүй, янз бүрээр тайлбарлагддаг

**Хөрөнгө оруулагч засгийн газартай татварын тогтворжуулалт дээр тохиролцоонд хүрч чадахгүй байгаагаас болоод хөрөнгө оруулалт хийх эсэхдээ эргэлзэх тохиолдол гарч байна. Засгийн газар дөрвөн төрлийн татварын хувь хэмжээг л тогтворжуулах хатуу байр суурьтай байхад хөрөнгө оруулагч бодит агуулгаар нь тогтворжуулах хүсэл сонирхолтой байдаг. Энэ нь зөвхөн тодорхой татварын хувь хэмжээг төдийгүй өргөн хүрээний татварын үр дагаврыг авч үзэж, татварын тогтворжуулалтын гэрчилгээ олгож татварын тогтвортой орчинг бүрэн хангах шаардлага байгааг анхаарах хэрэгтэйг харуулж байна.**





Засгийн Газар гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлэхгүй байх нь МУ-д оруулах гадаадын хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд одоогийн хөрөнгө оруулалтын гэрээгээр зөвхөн татварын хувь хэмжээг тогтворжуулдаг явдал нь хангалтгүй ба бусад татварын зохицуулалтууд өөрчлөгдөхөд дагаад татвар ногдох орлогыг өөрчилж, тогтворжуулсан хувь хэмжээнээс үл хамааран төлөх татварын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой байдаг. Жишээлбэл, хөрөнгийн элэгдлийн аргачлал өөрчлөгдөх эсвэл хасагдах зардлын шаардлагад өөрчлөлт орсноор татвар ногдох орлогыг нэмэгдүүлж, тогтворжуулсан хувь хэмжээний ашиг тусыг үгүй хийж болно. Тиймээс татварын тогтворжуулах гэрчилгээг олгоходоо зөвхөн тодорхой татварын хувь хэмжээг төдийгүй татварын үр дагаварыг агуулгаар нь тогтворжуулснаар жинхэнэ татварын тогтвортой орчинг бүрдүүлж чадна гэж бид үзэж байна.

## Хуульд оруулах өөрчлөлтийн санал:

Дээрх асуудлуудын хүрээнд хөрөнгө оруулагчдад итгэл өгсөн татварын ойлгомжтой, тогтвортой орчныг бүрдүүлэхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулах шаардлага үүсээд байна. Үүнд:

- Татварын тогтворжсон орчны талаарх зохицуулалт;
- Татварын тогтворжсон орчны хүрээнд үүссэн маргааныг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зэрэг асуудлын зохицуулт.

Дээрх зохицуулалтыг хуульчилж өгвөл Татвар, Хөрөнгө оруулалтын зохицуулалтын нэгдмэл байдал хангагдаж, хөрөнгө оруулалтын татварын орчны тогтвортой байдлын талаарх эрх зүйн зохицуулалт тодорхой болж, улмаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг татах үндэслэл бүрдэж, мега төслүүд амжилттэй хэрэгжих үндэс болно.





№	Бүтээг дэхүүний төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/	Бүтээгдэхүүний боловруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь							
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн					
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлээр/	0-5000 хүртэл	0.00	0.00	0.00					
					5000-6000 хүртэл	11.0	1.0	0.5				
					6000-7000 хүртэл	110 ам.дол. дээр 6000-с давсан үнийн дүнгийн 12%	10 ам.дол. дээр 6000-с давсан үнийн дүнгийн 2%	5 ам.дол. дээр 6000-с давсан үнийн дүнгийн 1%				
					7000-8000 хүртэл	230 ам.дол. дээр 7000-с давсан үнийн дүнгийн 13%	30 ам.дол. дээр 7000-с давсан үнийн дүнгийн 3%	15 ам.дол. дээр 7000-с давсан үнийн дүнгийн 1.5%				
					8000-9000 хүртэл	360 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 14%	60 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 4%	30 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 2%				
					9000 ба түүнээс дээш	500 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 15%	100 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 5%	50 ам.дол. дээр 9000-с давсан үнийн дүнгийн 2.5%				
					0-900 хүртэл			0.00				
					900-1000 хүртэл			1.00%				
					1000-1100 хүртэл			1 ам.дол. дээр 1000-с давсан үнийн дүнгийн 2.00%				
					1100-1200 хүртэл			3 ам.дол. дээр 1100-с давсан үнийн дүнгийн 3.00%				
2	Алт	унци	Алт /химийн цэврээр/	1200-1300 хүртэл			6 ам.дол. дээр 1200-с давсан үнийн дүнгийн 4.00%					
				1300 ба түүнээс дээш			10 ам.дол. дээр 1300-с давсан үнийн дүнгийн 5.00%					
				0-900 хүртэл								
				900-1000 хүртэл			1 ам.дол. дээр 1000-с давсан үнийн дүнгийн 2.00%					
3	Цайр	тн	Цайр /цэвэр металлээр/	0-1500 хүртэл	0.00	0.00	0.00					
					1500-2000 хүртэл	1.00 5 ам.дол. дээр 2000-с давсан үнийн дүнгийн 2%	0.80 4 ам.дол. дээр 2000-с давсан үнийн дүнгийн 1.5%	0.40 2 ам.дол. дээр 2000-с давсан үнийн дүнгийн 0.8%				
					2000-2500 хүртэл	2500-3000 хүртэл	15 ам.дол. дээр 2500-с давсан үнийн дүнгийн 3%	24 ам.дол. дээр 3000-с давсан үнийн дүнгийн 3.2%	6 ам.дол. дээр 2500-с давсан үнийн дүнгийн 1.2%			
					3000-3500 хүртэл	3500 ба түүнээс дээш	30 ам.дол. дээр 3000-с давсан үнийн дүнгийн 4%	40 ам.дол. дээр 3500-с давсан үнийн дүнгийн 4%	12 ам.дол. дээр 3000-с давсан үнийн дүнгийн 1.6%			
					0-35000 хүртэл	35000-40000 хүртэл	0.00	0.80	20 ам.дол. дээр 35000-с давсан үнийн дүнгийн 2%			
					40000-45000 хүртэл	45000-50000 хүртэл	1.00	40 ам.дол. дээр 40000-с давсан үнийн дүнгийн 1.6%	25 ам.дол. дээр 40000-с давсан үнийн дүнгийн 1%			
					40000-45000 хүртэл	45000-50000 хүртэл	50 ам.дол. дээр 45000-с давсан үнийн дүнгийн 2%	120 ам.дол. дээр 45000-с давсан үнийн дүнгийн 2.4%	7.5 ам.дол. дээр 45000-с давсан үнийн дүнгийн 1.5%			
					4	Молибдени	тн	Молибдени	45000-50000 хүртэл	150 ам.дол. дээр 45000-с давсан үнийн дүнгийн 3%	Унийн дүнгийн 3%	Унийн дүнгийн 1.5%



5	Төмөр	тн	Төмрийн хуцар	50000-55000 хуртэл	300 ам.дол дээр 50000-с давсан Үнийн дүнгийн 4%	240 ам.дол дээр 50000-с давсан Үнийн дүнгийн 3.5%	150 ам.дол дээр 50000-с давсан Үнийн дүнгийн 2%
				55000 ба түүнээс дээш	500 ам.дол дээр 55000-с давсан Үнийн дүнгийн 5%	400 ам.дол дээр 55000-с давсан Үнийн дүнгийн 4%	250 ам.дол дээр 55000-с давсан Үнийн дүнгийн 2.5%
				0-60 хуртэл	0.00	0.00	0.00
				60-70 хуртэл	0.1 ам.дол дээр 70-с давсан үнийн дүнгийн 2%	0.07 ам.дол дээр 70-с давсан Үнийн дүнгийн 1.4%	0.04 ам.дол дээр 70-с давсан үнийн дүнгийн 0.8%
				70-80 хуртэл	0.3 ам.дол дээр 80-с давсан үнийн дүнгийн 3%	0.21 ам.дол дээр 80-с давсан Үнийн дүнгийн 2.1%	0.12 ам.дол дээр 80-с давсан үнийн дүнгийн 1.2%
6	Гянтбогд	тн	Гянтбогдлын баяжмал	80-90 хуртэл	0.6 ам.дол дээр 90-с давсан үнийн дүнгийн 4%	0.42 ам.дол дээр 90-с давсан Үнийн дүнгийн 2.8%	0.24 ам.дол дээр 90-с давсан үнийн дүнгийн 1.6%
				90-100 хуртэл	1 ам.дол дээр 100-с давсан үнийн дүнгийн 5%	0.7 ам.дол дээр 100-с давсан Үнийн дүнгийн 3.5%	0.4 ам.дол дээр 100-с давсан үнийн дүнгийн 2%
				100 ба түүнээс дээш	0.00	0.00	0.00
				0-25000 хуртэл	1.00	0.80	-
				25000-30000 хуртэл	50 ам.дол дээр 30000-с давсан Үнийн дүнгийн 2%	40 ам.дол дээр 30000-с давсан Үнийн дүнгийн 1.6%	-
				30000-35000 хуртэл	150 ам.дол дээр 35000-с давсан Үнийн дүнгийн 3%	120 ам.дол дээр 35000-с давсан Үнийн дүнгийн 2.4%	-
				35000-40000 хуртэл	300 ам.дол дээр 40000-с давсан Үнийн дүнгийн 4%	240 ам.дол дээр 40000-с давсан Үнийн дүнгийн 3.2%	-
				40000-45000 хуртэл	500 ам.дол дээр 45000-с давсан Үнийн дүнгийн 5%	400 ам.дол дээр 45000-с давсан Үнийн дүнгийн 4%	-
				45000 ба түүнээс дээш	0.00	0.00	-
				0-80 хуртэл	1.00	0.90	-
7	Хайлуур жонш	тн	Хайлуур жоншны хуцар, баяжмал	80-90 хуртэл	0.1 ам.дол дээр 90-с давсан үнийн дүнгийн 2%	0.09 ам.дол дээр 90-с давсан Үнийн дүнгийн 1.8%	-
				90-100 хуртэл	0.3 ам.дол дээр 100-с давсан үнийн дүнгийн 3%	0.27 ам.дол дээр 100-с давсан Үнийн дүнгийн 2.7%	-
				100-110 хуртэл	0.6 ам.дол дээр 110-с давсан үнийн дүнгийн 4%	0.54 ам.дол дээр 110-с давсан Үнийн дүнгийн 3.6%	-
				110-120 хуртэл	1 ам.дол дээр 120-с давсан үнийн дүнгийн 5%	0.9 ам.дол дээр 120-с давсан Үнийн дүнгийн 4.5%	-
				120 ба түүнээс дээш	0.00	0.00	-
8	Жоншны баяжмал (флота цийн баяжмал)	тн	Жоншны баяжмал /флотацлийн баяжмал/	0-200 хуртэл	0.00	0.00	-
				200-290 хуртэл	0.00	0.00	-
				290-299 хуртэл	0.21 ам.дол дээр 290-с давсан үнийн дүнгийн 1.4%	0.165 ам.дол дээр 290-с давсан үнийн дүнгийн 2.1%	-
				299-320 хуртэл	1.26 ам.дол дээр 290-с давсан үнийн дүнгийн 2.8%	1.26 ам.дол дээр 290-с давсан үнийн дүнгийн 2.8%	-



9	Цагаан тугалга	ТН	Цагаан тугалга /Цэвэр металлгаар/	320 ба түүнээс Дээш		2.1 ам.долл дээр 320-с Давсан Үнийн дүнгийн 3.5%	
				0-17000 хүртэл	0.00	0.00	0.00
				17000-18000 хүртэл	1.00	0.80	0.50
				18000-19000 хүртэл	10 ам.долл дээр 18000-с Давсан Үнийн дүнгийн 2%	8 ам.долл дээр 18000-с Давсан Үнийн дүнгийн 1.6%	5 ам.долл дээр 18000-с Давсан Үнийн дүнгийн 1%
				19000-20000 хүртэл	30 ам.долл дээр 19000-с Давсан Үнийн дүнгийн 3%	24 ам.долл дээр 19000-с Давсан Үнийн дүнгийн 2.4%	15 ам.долл дээр 19000-с Давсан Үнийн дүнгийн 1.5%
				20000-21000 хүртэл	60 ам.долл дээр 20000-с Давсан Үнийн дүнгийн 4%	48 ам.долл дээр 20000-с Давсан Үнийн дүнгийн 3.2%	30 ам.долл дээр 20000-с Давсан Үнийн дүнгийн 2%
				21000 ба түүнээс Дээш	100 ам.долл дээр 21000-с Давсан Үнийн дүнгийн 5%	80 ам.долл дээр 21000-с Давсан Үнийн дүнгийн 4%	50 ам.долл дээр 21000-с Давсан Үнийн дүнгийн 2.5%
				0-1500 хүртэл	0.00	0.00	0.00
				1500-1800 хүртэл	1.00	0.80	0.40
				1800-2100 хүртэл	3 ам.долл дээр 1800-с Давсан Үнийн дүнгийн 2%	2.4 ам.долл дээр 1800-с Давсан Үнийн дүнгийн 1.6%	1.2 ам.долл дээр 1800-с Давсан Үнийн дүнгийн 0.8%
10	Хар тугалга	ТН	Хар тугалга /Цэвэр металлгаар/	2100-2400 хүртэл	9 ам.долл дээр 2100-с Давсан Үнийн дүнгийн 3%	7.2 ам.долл дээр 2100-с Давсан Үнийн дүнгийн 2.4%	3.6 ам.долл дээр 2100-с Давсан Үнийн дүнгийн 1.2%
				2400-2700 хүртэл	18 ам.долл дээр 2400-с Давсан Үнийн дүнгийн 4%	14.4 ам.долл дээр 2400-с Давсан Үнийн дүнгийн 3.2%	7.2 ам.долл дээр 2400-с Давсан Үнийн дүнгийн 1.6%
				2700 ба түүнээс Дээш	30 ам.долл дээр 2700-с Давсан Үнийн дүнгийн 5%	24 ам.долл дээр 2700-с Давсан Үнийн дүнгийн 4%	12 ам.долл дээр 2700-с Давсан Үнийн дүнгийн 2%
				0-25 хүртэл	0.00	-	-
				25-50 хүртэл	1.00	-	-
				50-75 хүртэл	0.25 ам.долл дээр 50-с Давсан Үнийн дүнгийн 2%	-	-
				75-100 хүртэл	0.75 ам.долл дээр 75-с Давсан Үнийн дүнгийн 3%	-	-
				100-125 хүртэл	1.5 ам.долл дээр 100-с Давсан Үнийн дүнгийн 4%	-	-
				125 ба түүнээс Дээш	2.5 ам.долл дээр 120-с Давсан Үнийн дүнгийн 5%	-	-
				11	Болговс руу-лаагүй нүүрс	ТН	Нүүрс
100-130 хүртэл	1.00	-	-				
130-160 хүртэл	-	0.3 ам.долл дээр 130-с Давсан Үнийн дүнгийн 1.5%	-				
160-190 хүртэл	-	0.75 ам.долл дээр 160-с Давсан Үнийн дүнгийн 2%	-				
190-210 хүртэл	-	1.35 ам.долл дээр 190-с Давсан Үнийн дүнгийн 2.5%	-				
12	Баяжуулсан нүүрс	ТН	Нүүрс	210 ба түүнээс Дээш	-	2.1 ам.долл дээр 210-с Давсан Үнийн дүнгийн 3%	-
				0-100 хүртэл	1.00	-	-
				100-130 хүртэл	-	0.3 ам.долл дээр 130-с Давсан Үнийн дүнгийн 1.5%	-
				130-160 хүртэл	-	0.75 ам.долл дээр 160-с Давсан Үнийн дүнгийн 2%	-
				160-190 хүртэл	-	1.35 ам.долл дээр 190-с Давсан Үнийн дүнгийн 2.5%	-



				320 ба түүнээс дээш		2.1 ам.дол дээр 320-с давсан Үнийн дүнгийн 3.5%	
9	Цагаан тулгалта	ТН	Цагаан тулгалта /цэвэр металлаар/	0-17000 хүртэл	0.00	0.00	0.00
				17000-18000 хүртэл	1.00	0.80	0.50
				18000-19000 хүртэл	10 ам.дол дээр 18000-с давсан	8 ам.дол дээр 18000-с давсан	5 ам.дол дээр 18000-с давсан үнийн дүнгийн 1%
				19000-20000 хүртэл	Үнийн дүнгийн 2%	24 ам.дол дээр 19000-с давсан	15 ам.дол дээр 19000-с давсан үнийн дүнгийн 1.5%
				20000-21000 хүртэл	30 ам.дол дээр 19000-с давсан	Үнийн дүнгийн 2.4%	30 ам.дол дээр 20000-с давсан үнийн дүнгийн 2%
				21000 ба түүнээс дээш	60 ам.дол дээр 20000-с давсан	48 ам.дол дээр 20000-с давсан үнийн дүнгийн 3.2%	50 ам.дол дээр 21000-с давсан үнийн дүнгийн 2.5%
					100 ам.дол дээр 21000-с давсан	80 ам.дол дээр 21000-с давсан үнийн дүнгийн 4%	0.00
					Үнийн дүнгийн 5%	0.00	0.40
					0-1500 хүртэл	0.00	
					1500-1800 хүртэл	1.00	
10	Хар тулгалта	ТН	Хар тулгалта /цэвэр металлаар/	1800-2100 хүртэл	3 ам.дол дээр 1800-с давсан үнийн дүнгийн 2%	2.4 ам.дол дээр 1800-с давсан үнийн дүнгийн 1.6%	1.2 ам.дол дээр 1800-с давсан үнийн дүнгийн 0.8%
				2100-2400 хүртэл	9 ам.дол дээр 2100-с давсан үнийн дүнгийн 2%	7.2 ам.дол дээр 2100-с давсан үнийн дүнгийн 2.4%	3.6 ам.дол дээр 2100-с давсан үнийн дүнгийн 1.2%
				2400-2700 хүртэл	18 ам.дол дээр 2400-с давсан үнийн дүнгийн 4%	14.4 ам.дол дээр 2400-с давсан үнийн дүнгийн 3.2%	7.2 ам.дол дээр 2400-с давсан үнийн дүнгийн 1.6%
				2700 ба түүнээс дээш	30 ам.дол дээр 2700-с давсан үнийн дүнгийн 5%	24 ам.дол дээр 2700-с давсан үнийн дүнгийн 4%	12 ам.дол дээр 2700-с давсан үнийн дүнгийн 2%
					0-25 хүртэл	0.00	
					25-50 хүртэл	1.00	
					50-75 хүртэл	0.25 ам.дол дээр 50-с давсан үнийн дүнгийн 2%	
					75-100 хүртэл	0.75 ам.дол дээр 75-с давсан үнийн дүнгийн 3%	
					100-125 хүртэл	1.5 ам.дол дээр 100-с давсан үнийн дүнгийн 4%	
					125 ба түүнээс дээш	2.5 ам.дол дээр 120-с давсан үнийн дүнгийн 5%	
11	Боловсруу-лаагүй нүүрс	ТН	Нүүрс	0-100 хүртэл		0.00	
				100-130 хүртэл		1.00	
				130-160 хүртэл			
				160-190 хүртэл		0.75 ам.дол дээр 160-с давсан үнийн дүнгийн 2%	
				190-210 хүртэл		1.35 ам.дол дээр 190-с давсан үнийн дүнгийн 2.5%	
				210 ба түүнээс дээш		2.1 ам.дол дээр 210-с давсан үнийн дүнгийн 3%	
12	Баяжуу лсан нүүрс	ТН	Нүүрс	0-100 хүртэл		0.00	
				100-130 хүртэл		1.00	
				130-160 хүртэл			
				160-190 хүртэл		0.75 ам.дол дээр 160-с давсан үнийн дүнгийн 2%	
				190-210 хүртэл		1.35 ам.дол дээр 190-с давсан үнийн дүнгийн 2.5%	
				210 ба түүнээс дээш		2.1 ам.дол дээр 210-с давсан үнийн дүнгийн 3%	



13	Эцсийн бүтээгдэхүүн (Хатас кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	ТН	Кокс	0-160 хүртэл	-	-	0.00
				160-190 хүртэл			0.50
14	Мөнгө	Унци	Мөнгө /Химийн цэврээр/	0-25 хүртэл	-	-	0.00
				25-30 хүртэл			1.00
				30-35 хүртэл			
				35-40 хүртэл			0.05 ам.долл дээр 30-с давсан үнийн дүнгийн 2%
				40-45 хүртэл			0.15 ам.долл дээр 35-с давсан үнийн дүнгийн 3%
15	Магnez ит	ТН	Магnezитийн баяжмал	40-45 хүртэл	-	-	0.3 ам.долл дээр 40-с давсан үнийн дүнгийн 4%
				45 ба түүнээс дээш			0.5 ам.долл дээр 45-с давсан үнийн дүнгийн 5%
				0-100 хүртэл			0.00
				100-120 хүртэл			0.90
				120-140 хүртэл			0.18 ам.долл дээр 120-с давсан үнийн дүнгийн 1.8%
16	Хөнгөн цагаан	ТН	Хөнгөн цагаан /Цэвр металлээр/	140-160 хүртэл	-	-	0.54 ам.долл дээр 140-с давсан үнийн дүнгийн 2.7%
				160-180 хүртэл			1.08 ам.долл дээр 160-с давсан үнийн дүнгийн 3.6%
				180 ба түүнээс дээш			1.8 ам.долл дээр 180-с давсан үнийн дүнгийн 4.5%
				0-2300 хүртэл			0.00
				2300-2600 хүртэл			0.90
16	Хөнгөн цагаан	ТН	Хөнгөн цагаан /Цэвр металлээр/	2600-2900 хүртэл	-	-	1.5 ам.долл дээр 2600-с давсан үнийн дүнгийн 1%
				2900-3200 хүртэл			4.5 ам.долл дээр 2900-с давсан үнийн дүнгийн 1.5%
				3200-3500 хүртэл			8.1 ам.долл дээр 3200-с давсан үнийн дүнгийн 2.7%



13	Эцсийн бүтээгдэхүүн (Хатас кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	ТН	Кокс	0-160 хүртэл				0.00
				160-190 хүртэл				0.50
14	Мөнгө	Унци	Мөнгө /Химийн цэврээр/	0-25 хүртэл				0.00
				25-30 хүртэл				1.00
				30-35 хүртэл				
				35-40 хүртэл				0.05 ам.долл дээр 30-с давсан үнийн дүнгийн 2%
				40-45 хүртэл				0.15 ам.долл дээр 35-с давсан үнийн дүнгийн 3%
15	Магnez ит	ТН	Магnezийн баяжмал	40-45 хүртэл				0.3 ам.долл дээр 40-с давсан үнийн дүнгийн 4%
				45 ба түүнээс дээш				0.5 ам.долл дээр 45-с давсан үнийн дүнгийн 5%
				0-100 хүртэл				0.00
				100-120 хүртэл				0.90
				120-140 хүртэл				0.18 ам.долл дээр 120-с давсан үнийн дүнгийн 1.8%
16	Хөнгөн цагаан	ТН	Хөнгөн цагаан /Цэвр металлээр/	140-160 хүртэл				0.54 ам.долл дээр 140-с давсан үнийн дүнгийн 2.7%
				160-180 хүртэл				1.08 ам.долл дээр 160-с давсан үнийн дүнгийн 3.6%
				180 ба түүнээс дээш				1.8 ам.долл дээр 180-с давсан үнийн дүнгийн 4.5%
				0-2300 хүртэл				0.00
				2300-2600 хүртэл				0.90
16	Хөнгөн цагаан	ТН	Хөнгөн цагаан /Цэвр металлээр/	2600-2900 хүртэл				2.7 ам.долл дээр 2600-с давсан үнийн дүнгийн 1.8%
				2900-3200 хүртэл				8.1 ам.долл дээр 2900-с давсан үнийн дүнгийн 2.7%
				3200-3500 хүртэл				15 ам.долл дээр 3200-с давсан үнийн дүнгийн 1%
16	Хөнгөн цагаан	ТН	Хөнгөн цагаан /Цэвр металлээр/	3500-3800 хүртэл				4.5 ам.долл дээр 3500-с давсан үнийн дүнгийн 1.5%
				3800-4100 хүртэл				13.5 ам.долл дээр 3800-с давсан үнийн дүнгийн 3.4%
				4100-4400 хүртэл				22.5 ам.долл дээр 4100-с давсан үнийн дүнгийн 4.5%



Т	Хийсэн	ТН	Кокс	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)		Мөнгө /Химийн цэврээр/		Мөнгө	
				0-160 хүртэл	160-190 хүртэл	0-25 хүртэл	25-30 хүртэл	30-35 хүртэл	35-40 хүртэл
13		ТН	Кокс	0-160 хүртэл	-	-	0.00		
				160-190 хүртэл			0.50		
				190-210 хүртэл					0.15 ам.долл дээр 190-с давсан үнийн дүнгийн 1%
				210-240 хүртэл					0.45 ам.долл дээр 210-с давсан үнийн дүнгийн 1.5%
				240-270 хүртэл					0.9 ам.долл дээр 240-с давсан үнийн дүнгийн 2%
14	Мөнгө	Унц	Мөнгө /Химийн цэврээр/	270 ба түүнээс дээш					1.5 ам.долл дээр 270-с давсан үнийн дүнгийн 2.5%
				0-25 хүртэл			0.00		
15	Магnez ит	ТН	Магnezитийн баяжмал	0-100 хүртэл	0.00	0.00			
				100-120 хүртэл	1.00	0.90			
				120-140 хүртэл	0.2 ам.долл дээр 120-с давсан үнийн дүнгийн 2%	0.18 ам.долл дээр 120-с давсан үнийн дүнгийн 1.8%			
				140-160 хүртэл	0.6 ам.долл дээр 140-с давсан үнийн дүнгийн 3%	0.54 ам.долл дээр 140-с давсан үнийн дүнгийн 2.7%			
				160-180 хүртэл	1.2 ам.долл дээр 160-с давсан үнийн дүнгийн 4%	1.08 ам.долл дээр 160-с давсан үнийн дүнгийн 3.6%			
				180 ба түүнээс дээш	2 ам.долл дээр 180-с давсан үнийн дүнгийн 5%	1.8 ам.долл дээр 180-с давсан үнийн дүнгийн 4.5%			
				0-2300 хүртэл	0.00	0.00			0.00
				2300-2600 хүртэл	1.00	0.90			0.50
				2600-2900 хүртэл	3 ам.долл дээр 2600-с давсан үнийн дүнгийн 2%	2.7 ам.долл дээр 2600-с давсан үнийн дүнгийн 1.8%			1.5 ам.долл дээр 2600-с давсан үнийн дүнгийн 1%
				2900-3200 хүртэл	9 ам.долл дээр 2900-с давсан үнийн дүнгийн 3%	8.1 ам.долл дээр 2900-с давсан үнийн дүнгийн 2.7%			4.5 ам.долл дээр 2900-с давсан үнийн дүнгийн 1.5%